

Монгол улсын Санхүүгийн зохицуулах хорооны
2012 он 02 дугаар сарын 15-ны өдрийн 34 дүгээр
Тогтоолын 2 дугаар хавсралт

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр: Багануур Хувьцаат Компани

Хаяг, утас: Улаанбаатар хот, Багануур дүүрэг, 3-р хороо,
Үйлдвэрийн хэсэг, Өөрийн байр
Утас: 7021-0114; 7021-3739

Хурал хуралдах огноо, цаг, газар:
2015 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 14.00 цагт
Улаанбаатар хот Багануур дүүрэгт орших Багануур ХК-
ийн хурлын танхимд

Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо:
Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 01 дүгээр сарын
13-ны өдрийн 01 тоот тогтоол

Олон нийтэд зарлах огноо:
2015 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр

Бүртгэх өдөр 2014 оны 12 дугаар сарын 01-ний өдөр

Гэрээний дагуу хурлын баримт бичгийг брокер дилерийн компанид хүргүүлэх огноо

Хүргүүлсэн огноо

Хурлын баримт, бичгийн хуудасны тоо 4 ширхэг, 5 хуудас

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ
КОМИССЫН ДАРГА /Л.ШАГДАРСҮРЭН/

2015 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр

ХҮЛЭЭН АВСАН:
БҮРТГЭЛИЙН МЭРГЭЖИЛТЭН /...../

2015 оны 01 дүгээр сарын ... -ны өдөр

5

**“БАГАНУУР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ**

2014 оны 12 дугаар
сарын 24-ны өдөр

Дугаар 1

Багануур

Ирцийн тухай

“Багануур” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд ирвэл зохих 20,974,360 ширхэг хувьцаанаас брокерын пүүсүүдээс хуралд оролцох санал ирээгүй, 0 хүн итгэмжлэлээр 0 ширхэг хувьцааг төлөөлж, 572 ширхэг хувьцаа эзэмшигч 2 хүн өөрийн биеээр, 572 хувьцаа эзэмшигч оролцож хурал 0,0027 % ирцтэй байна. / Бүртгэлийг хавсаргав/

1. “Багануур” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг “Компаний тухай хууль”-ийн 69.1, “Компанийн дүрэм”-ийн 9.7 заалтын дагуу саналын эрхтэй хувьцааны 50-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцоогүй тул хүчин төгөлдөр бус гэж үзсүгэй.

ТООЛЛОГЫН КОМИСС:

ДАРГА
ГИШҮҮД



Ч.ОЧИРЛХАМ
Д.ТҮВШИНТӨГС
Д.ДАВААДАШ

7

**Багануур ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн
ээлжит бус хурлын тэмдэглэл**

2014.12.24

Багануур

Багануур ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014.11.13-ны өдрийн 27 тоот тогтоолоор зарлагдсан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2014.12.24-ны өдөр компанийн хурлын танхимд 14.00-цагаас эхлэхээр товлогдсны дагуу тооллогын комисс 13.00 цагаас бүртгэлийн үйл ажиллагааг эхлүүлсэн.

Хуралд саналын эрхтэй 572 ш хувьцааг эзэмшигч Ж.Цэдэнсодном 14.10 цагт, Д.Түвшинтөгс 13.30 цагт ирж бүртгэгдсэн.

Тооллогын комиссыг 15.00 цаг хүртэл ажиллахад нэмж саналын эрхтэй хувьцаа эзэмшигч хүрэлцэн ирээгүйн улмаас хурлыг компаний тухай хуулийн 69.1-д заасан ирц хүрээгүй үндэслэлээр хүчин төгөлдөр бусад тооцон тооллогын комисс 01 тоот тогтоол гаргаж, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Л.Шагдарсүрэнд хүргүүлсэн болно.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Д.Ганчимэг

Танилцсан:

Л.Шагдарсүрэн



8

**“БАГАНУУР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2015 оны 01 сарын 13 өдөр

Дугаар 01

Багануур

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус
хурлын товыг дахин тогтоох тухай

Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.3, 69.6 дах заалтыг тус тус
үндэслэн ТОГТООХ нь:

1. Багануур ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2015 оны 01
дүгээр сарын 23-ний өдрийн 14.00 цагт Улаанбаатар хот Багануур дүүрэгт орших
Багануур ХК-ийн хурлын танхимд хуралдуулсугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд
хуулийн дагуу мэдээлэхийг Хурал зохион байгуулах комиссын дарга
/Л.Шагдарсүрэн/-д үүрэг болгосугай.

ДАРГА  Р.ЖИГЖИД

